



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ДОТООД АУДИТЫН НЭГДСЭН БОДЛОГО,
ЧИГ ҮҮРЭГ НЬ УЯЛДААГҮЙ
БАЙНА.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн
хэрэгжилт” хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

АУДИТЫН КОД: ДОА-2021/15-10-ШТА-ГА

Чойбалсан хот 2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Батжаргал
Утас: 7058-4207, Цахим хаяг: batjargalb@audit.gov.mn
Аудитор Б.Одхүү
Утас: 7058-4207, Цахим хаяг: odkhuu@audit.gov.mn
Аудитор Ж.Баяртуул
Утас: 7058-4207, Цахим хаяг: bayartuulj@audit.gov.mn
Гэрээт аудитор Б.Оюунхэрлэн
Утас: 7058-4207, Цахим хаяг: oyunkherlenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn



АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	4
БҮЛЭГ А. ДОТООД АУДИТЫН ЭРХ ЗҮЙН ЗААЛТУУД ХООРОНДОО УЯЛДААГҮЙ, ХАРААТ БУСААР АЖИЛЛАХ НӨХЦӨЛ БОЛОМЖООР БҮРЭН ХАНГАГДААГҮЙ БАЙНА.....	5
А.1.1 Төрийн байгууллагын дотоод аудитын эрх зүйн зохицуулалт уялдаа холбоогүй байна.....	5
А.1.2 Дотоод аудитын нэгжийн зорилго, эрх мэдэл, үүрэг хариуцлагыг дотоод аудитын дүрэмд тусгасан байна.....	5
А.2.1 Санхүүгийн хяналт, аудитын алба нь чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх бүтэц, хөрөнгө, орон тоотой байна.....	6
А.2.2 Хараат бусаар ажиллах нөхцөл боломжоор бүрэн хангагдаагүй байна.....	6
А.2.3 Дотоод аудиторууд нь хууль, дүрэмд заасан шалгуурыг бүрэн хангаагүй байна.....	7
БҮЛЭГ Б. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДОТООД АУДИТ ЧИГ ҮҮРГЭЭ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.....	7
Б.1.1 Дотоод аудитын дүрэмд заасны дагуу дотоод аудитын хороог байгуулаагүй байна.....	7
Б.1.2 Дотоод аудитын нэгж чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.	8
Б.1.3 Дотоод аудитын нэгжийн дүрмийг шинэчлэн боловсруулаагүй байна.....	9
Б.1.4 Дотоод аудитын тайланг иргэд олон нийтэд мэдээлэх мэдээллийн нэгдсэн сан байхгүй байна...	9
Б.1.5 Сангийн яаманд санхүүгийн хяналт, аудитын албаны тайланг хүргүүлсэн байна.....	9
Б.2.1 Санхүүгийн хяналт, аудитын албанд чанарын хяналтын үнэлгээ хийгдээгүй байна.....	10
Б.2.2 Дотоод аудитаар өгсөн зөвлөмжийг бүртгэн, биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй байна.....	10
Б.2.3 Дотоод аудитын үр дүнд төсвийн хөрөнгийг анхан шатны баримтгүй зарцуулах, зориулалт бусаар зарцуулах зэрэг зөрчил буурсан байна.....	11
 ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:.....	 11-12
ДҮГНЭЛТ:.....	13
НЭГДСЭН ТАЙЛАНД ТУСГУУЛАХ САНАЛ:.....	13
ЗӨВЛӨМЖ:.....	14
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:.....	15



Товчилсон үгийн тайлбар

ГА	Гүйцэтгэлийн аудит
ТАБ	Төрийн аудитын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
MNS	Монгол Улсын Стандарт
ШТА	Шууд тайлагнах аудит
ЗГ	Засгийн газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
ДИХ	Дорнод Их Сургууль
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт



	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/28 тоот тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын 2021 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн.
Аудитын зорилт	Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилтийн байдалд аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, аудитын дүнг УАГ-т хүргүүлж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Дээрх зорилтын хүрээнд дараах дэд зорилтын дагуу аудитыг гүйцэтгэсэн. Үүнд: • Төрийн байгууллагын дотоод аудитын тогтолцоо оновчтой эсэх. • ТЕЗ-ын дотоод аудитын нэгж чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад орон нутагт дотоод аудитын зорилго, зорилт, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөө, ажилтнуудын судалгаа, санхүүгийн тайлан, дотоод аудит хийсэн баримт материалыг шалгасан.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 "Төрийн аудит, Тулгуур зарчим", MNS 6817-5:2020 "Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим", MNS 6817-7:2020 "Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудит" стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, гүйцэтгэлийн аудит хийх аргачлалын дагуу холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар, тодруулга авах, шалгагдагч байгууллагаас авсан судалгаа, мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горимуудыг ашиглав.
Үндсэн мэдээлэл	Төсвийн тухай хуульд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албыг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангаж, төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна гэж заасан байна. Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-д төрийн байгууллагуудын дотоод аудитын албаны үйл ажиллагаанд бүх төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн засаг захиргааны дотоод аудитын алба, тэдгээрийн харьяа байгууллагын дотоод аудитын албадын төсөв, санхүүгийн үйл ажиллагаа хамаарахаар тусгагдсан байна.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Батжаргал, аудитор Б.Одхүү, Ж.Баяртуул, гэрээт аудитор Б.Оюунхэрлэн нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэсэн.



БҮЛЭГ А. ДОТООД АУДИТЫН ЭРХ ЗҮЙН ЗААЛТУУД ХООРОНДОО УЯЛДААГҮЙ, ХАРААТ БУСААР АЖИЛЛАХ НӨХЦӨЛ БОЛОМЖООР БҮРЭН ХАНГАГДААГҮЙ БАЙНА.

А.1 Дотоод аудитын эрх зүйн заалтууд хоорондоо уялдаагүй, эрх зүйн орчин хангалтгүй байна.

А.1.1 Төрийн байгууллагын дотоод аудитын эрх зүйн зохицуулалт уялдаа холбоогүй байна.

Санхүүгийн хяналт аудитын алба нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3-т заасны дагуу ТЕЗ-ын эрхлэх асуудлын хүрээний 175 байгууллагыг хамруулан чиг үүргээ гүйцэтгэсэн байна. Төсвийн тухай хуульд зааснаар Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал шийдвэрээр дотоод аудитын үйл ажиллагааг зохицуулж байна. Дотоод аудитын эрх зүйн зохицуулалт уялдаагүй дараах заалтууд байна. Үүнд:

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1. "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна." гэж заасан. Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5. "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 16.5.6. дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;" гэж заасан ч хэрхэн хэрэгжүүлэхийг хууль, дүрмээр заагаагүй байна.

Төсвийн шууд захирагчийн байгууллагуудад ТЕЗ-ын дотоод аудитын нэгж, дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлж байхад хуульд төсвийн шууд захирагчид дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр заасан нь хуулийн заалт хоорондын уялдаагүй байдлыг харуулж байна.

Засгийн газрын 2016 оны 9 дүгээр тогтоолоор баталсан аймгийн Засаг даргын тамгын газрын бүтцэд "Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс"-тэй байхаар заасан байна.

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-д заасан дотоод аудитын чиг үүргийг Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлж байна. Аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь хяналт-шинжилгээ, үнэлгээний чиг үүргийг гүйцэтгэж байна.

Дээрхээс дүгнэхэд дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэггүй хэлтсийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс гэсэн нь Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-д заасантай нийцэхгүй байна.

А.1.2 Дотоод аудитын нэгжийн зорилго, эрх мэдэл, үүрэг хариуцлагыг дотоод аудитын дүрэмд тусгасан байна.

Аймгийн санхүүгийн хяналт, аудитын алба нь үйл ажиллагаандаа Засгийн газрын 2015 оны 483 дүгээр тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм"-ийг мөрдөн ажиллаж байна. Дотоод аудитын нэгжийн дүрмийг аймгийн Засаг даргын 2014 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/467 дугаар захирамжаар батлуулсан байна.



Дээрх дүрмүүдэд дотоод аудитын нэгжийн зорилго, эрх, үүрэг хариуцлагыг тусгасан байна.

А.2 Санхүүгийн хяналт, аудитын алба нь чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх бүтэц, хөрөнгө, орон тоотой ч хараат бусаар ажиллах нөхцөл боломжоор бүрэн хангагдаагүй байна.

А.2.1 Санхүүгийн хяналт, аудитын алба нь чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх бүтэц, хөрөнгө, орон тоотой байна.

Дорнод аймгийн Засаг дарга нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д заасны дагуу Санхүүгийн хяналт, аудитын албыг байгуулж үйл ажиллагааг нь хэвийн явуулах ажлын байр, албан өрөөний тавилга, суудлын автомашин, компьютер, тоног төхөөрөмжөөр ханган ажилласан байна. Аймгийн Засаг даргын 2020 оны Б/25 дугаар захирамжаар Санхүүгийн хяналт, аудитын албаны бүтэц, орон тоог 12 албан хаагчтай байхаар баталсан байна.

А.2.2 Хараат бусаар ажиллах нөхцөл боломжоор бүрэн хангагдаагүй байна.

Аймгийн ИТХ-аас Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны төсвийг 218.2 сая төгрөгөөр баталсан байна.

Сангийн яамнаас санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2020 оны төсвийг хянахдаа орон тоог 7, төсвийг нь 148.6 сая төгрөг байхаар хянаж ирүүлсэн байна. Тус албаны орон тоо, төсвийг дутуу хянаж ирүүлсэн шалтгааныг тодруулахад:

Санхүүгийн хяналт, аудитын албаны төсвийг Сангийн яамнаас хянахдаа аймгийн Засаг даргын баталсан орон тоог харгалзан үзэлгүй анх Мэргэжлийн хяналтын газраас шилжиж ирсэн улсын байцаагчдын тоогоор орон тооны хязгаарыг албаны бүтэц, орон тооны хязгаар мэтээр тусган хянаж ирүүлдэгт байна. Энэ талаар Төрийн аудитын байгууллагаас аймгийн төсвийн төсөлд өгсөн санал дүгнэлтэд тусгасан ч бүрэн шийдвэрлэгдээгүй байна.

Сангийн яамнаас Дотоод аудитын үйл ажиллагааг бэхжүүлэхэд шаардлагатай төсвийн байгууллагын бүтэц болон орон тооны жишиг, хязгаарыг аймгуудын хэмжээнд хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ, эдийн засгийн чадавх зэргийг харгалзан тогтоох шаардлагатай байна.

Санхүүгийн хяналт, аудитын албаны дотоод аудиторын албан тушаалын цалин, нийгмийн баталгаа, эрх зүйн байдал нь хууль, тогтоомжоор тусгайлан батлагдаагүй байна.

Дээрх нөхцөл байдлаас харахад хараат бусаар ажиллах нөхцөл боломжоор бүрэн хангагдаагүй байна.



А.2.3 Дотоод аудиторуд нь хууль, дүрэмд заасан шалгуурыг бүрэн хангаагүй байна.

Дотоод аудиторуд дотоод аудитын дүрэмд заасан шалгуурыг хангаж байгаа эсэхийг үзэхэд 7 дотоод аудиторын 2 нь магистр зэрэгтэй, 5 нь дүрэмд заасан санхүү, нягтлан бодох бүртгэл, эдийн засаг, эрх зүйн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй гэсэн шалгуурыг хангахгүй байна.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.4-т “Дотоод аудитор нь санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн эрхтэй байна.” гэж заасан.

Аймгийн Засаг даргын баталсан орон тоогоор Санхүүгийн хяналт, аудитын албанд санхүүгийн хяналт шалгалтын эрхтэй 7 дотоод аудитор ажиллахаас улсын ахлах байцаагчийн эрхтэй 2, улсын байцаагчийн эрхтэй 3 дотоод аудитор нийт санхүүгийн хяналт шалгалтын эрхтэй 5 дотоод аудитор ажиллаж байна. Улсын байцаагчийн эрх аваагүй 2 дотоод аудитор байна.

БҮЛЭГ Б. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДОТООД АУДИТ ЧИГ ҮҮРГЭЭ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

Б.1 Төрийн байгууллагуудын дотоод аудит чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Б.1.1 Дотоод аудитын дүрэмд заасны дагуу дотоод аудитын хороог байгуулаагүй байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба 2014-2019 он хүртэл дотоод аудитыг санхүүгийн хяналт шалгалтын стандартаар гүйцэтгэж байсан байна. Тус алба нь 2020 оноос Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар батлагдсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ын дагуу дотоод аудитыг хийсэн байна.

Сангийн сайдын 2019 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан дотоод аудитын хорооны дүрмийн 1.3-д “эрхлэх асуудлынхаа хүрээнд 5 буюу түүнээс дээш төсвийн байгууллагатай ТЕЗ нь дэргэдээ дотоод аудитын хороотой байна” гэж заасан. Дээрх заалтын хэрэгжилтийг шалгахад аймгийн ТЕЗ нь дэргэдээ дотоод аудитын хороогүй байна.



Б.1.2 Дотоод аудитын нэгж чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын 2018-2020 оны шууд тайлагналын аудитуудад судалгаа хийж үзэхэд төсөвт байгууллагуудын дотоод хяналтын үр нөлөө хангалтгүй талаар дүгнэж, зөвлөмжүүд өгсөн байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1

он	Аудитын нэр	Зөвлөмжийн утга	Байгууллагын нэр
2018	Төсвийн тухай хуулийн хэрэгжилт	ТЕЗ-ийн хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоод хяналтын үр нөлөөг сайжруулахад анхаарах	Санхүүгийн хяналт, аудитын алба
	Цагдаагийн газрын үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн	дотоод хяналтын үр нөлөөг сайжруулах.	Цагдаагийн газар
	хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас олгож буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн	төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналтыг чанаржуулж, үр дүнг бодитоор тооцох	Аймгийн ХХҮГ
	Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн	Төрийн сангийн үйл ажиллагааны эрсдэлийг бодитой тооцож, хяналтын хүрээг нэмэгдүүлж, үр нөлөөг сайжруулах	Аймгийн Засаг даргад
2019	Орон нутгийн төсвийн 2018 оны хөрөнгө оруулалт	хяналт шалгалтыг дуусгаж үр дүнг танилцуулах	Аймгийн Засаг даргад
	МХГ-ын үйл ажиллагааны хэрэгжилт	Дотоод хяналтын үр нөлөөг сайжруулах	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар
	Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалт	Дотоод хяналтын үр нөлөөг сайжруулах	Аймгийн Засаг даргад
	Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын худалдан авах үйл ажиллагаа	Дотоод хяналт шалгалтыг хийж байх	Өмчит газруудад
	Орон нутгийн хөрөнгө оруулалтын бус хөтөлбөр арга хэмжээ	Хяналт шалгалт хийхээр тусгах	Аймгийн Засаг даргад
	Сургуулийн өмнөх боловсрол олгож буй өнөөгийн байдал	Дотоод хяналтын үр нөлөөг сайжруулах	Боловсрол соёл урлагын газарт
2020	Төрөөс бүх нийтийн боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн	Сургуулиудын дотоод хяналтын үр нөлөөг сайжруулах	ЕБС-ийн захирлуудад
	Дорнод аймагт үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн боловсролын болон их дээд сургуулиудын үйл ажиллагааны үр дүн	Дотоод хяналтын үр нөлөөг сайжруулах	Политехник коллеж, МСҮТ, ДИС-ын удирдлагуудад
	Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалт	УТХО-ын ажлуудад тавих дотоод хяналтыг цаг хугацаанд нь хийж, үр ашгийг тооцон, үр дүнг үнэлэх	Аймгийн Засаг даргад

Дээрхээс судалгаанаас харахад төрийн байгууллагуудын дотоод аудит чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.



Б.1.3 Дотоод аудитын нэгжийн дүрмийг шинэчлэн боловсруулаагүй байна.

Дотоод аудитын нэгж нь стандартад санхүү хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэхийн тулд нэгжийн үйл ажиллагааны зорилго, зарчим, санхүүгийн хяналт шалгалт явуулах, ажлын үр дүнгээ тайлагнах дүрэмтэй байна гэж заасан байна.

Санхүү хяналт, аудитын алба нь Засаг даргын 2014 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/467 дугаар захирамжаар батлагдсан Дотоод аудитын албаны дүрэмтэй ч Засгийн газрын 2015 оны 483 дүгээр тогтоолоор батлагдсан “дотоод аудитын дүрэм”-ийн зарим заалтуудтай нийцэхгүй байна. Дотоод аудитын нэгжийн дүрмийг шинэчлэн аймгийн Засаг даргаар батлуулах шаардлагатай байна.

Тус алба нь тухайн жилийн төлөвлөгөө, дотоод аудитын удирдамжийг батлуулж, түүний хэрэгжилтийн явцыг улирал, хагас, бүтэн жилээр тайлагнаж байгаа ч дотоод аудитын дүрэмд заасан нэгжийн дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулаагүй байна.

Б.1.4 Дотоод аудитын тайланг иргэд олон нийтэд мэдээлэх мэдээллийн нэгдсэн сан байхгүй байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь санхүүгийн тайлан, батлагдсан төсөв зэргийг байгууллагынхаа мэдээллийн самбарт байршуулахаас гадна иргэд олон нийтэд facebook хуудсаараа өөрийн байгууллагын үйл ажиллагааг мэдээлж байна.

Дорнод аймгийн www.dornod.gov.mn цахим хуудсанд цэсгүйгээс мэдээлэл байршуулаагүй байна. Дотоод аудитын тайланг иргэд олон нийтэд мэдээлэх мэдээллийн нэгдсэн сан байхгүй байна.

Б.1.5 Сангийн яаманд санхүүгийн хяналт, аудитын албаны тайланг хүргүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс Санхүүгийн хяналт, аудитын алба нь харилцан хамааралгүй ажилладаг байна.

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-д заасан дотоод аудитын чиг үүргийг аймгийн хэмжээнд Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлж байна.

Аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь зөвхөн хяналт-шинжилгээ хийдэг байна. Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-д заасан дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэггүй байна.

Тус алба нь Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт дотоод аудитын хагас, бүтэн жилийн тайлан, мэдээг хүргүүлж ажилласан байна.



Б.2 Санхүүгийн хяналт, аудитын албанд чанарын хяналтын үнэлгээ хийгдээгүй байна.

Б.2.1 Санхүүгийн хяналт, аудитын албанд чанарын хяналтын үнэлгээ хийгдээгүй байна.

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 8.5-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчийн болон бусад төсвийн захирагчдын дотоод аудитын үйл ажиллагаанд дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу чанарын хяналтын үнэлгээг 2 жилд 1 удаа хийнэ.” гэж заасан байна.

Дээрх заалтын хэрэгжилтийг үзэхэд Сангийн яамнаас аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд чанарын хяналтын үнэлгээг хийгээгүй байна.

Хөндлөнгийн хяналтын байгууллага болох Дорнод аймаг дахь төрийн аудитын газар нь төлөвлөгөөний дагуу хийгдсэн гүйцэтгэлийн болон нийцлийн аудитуудын хүрээнд тухайн асуудлаар дотоод аудит хийгдсэн эсэхийг шалгаж дүгнэлт, зөвлөмж өгсөн байна.

Б.2.2 Дотоод аудитаар өгсөн зөвлөмжийг бүртгэн, биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2019-2020 онуудад тавьсан төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтийг тулган шалгасан. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2

Он	Акт	Албан шаардлага	Зөрчлийн дүн	Биелэлт	Хувиар
2019 он	1.097,8	2.162,3	3260.1	2.941,3	90.0
2020 он	352.3	882.4	1234.7	864.2	70.0

Дээрх хүснэгтээс харахад 2019 онд төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт 90 хувьтай байсан бол 2020 онд 70 хувьтай гарч өмнөх оноос 20 хувиар буурсан байна.

Дотоод аудитын тайлан, статистик мэдээнээс үзэхэд дотоод аудитаар илэрсэн алдаа, зөрчилд санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн акт, албан шаардлага тавьж ажилласан байна.

Дотоод аудитаар зөвлөмж өгдөг ч зөвлөмжийг бүртгэл, зөвлөмжийн биелэлтийг гаргасан статистик, мэдээ баримт байхгүй байна. Энэ нь Төсвийн тухай хууль болон дотоод аудитын дүрэмд заасан зөвлөмж гарган тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх гэсэн зорилгоо бүрэн биелүүлээгүйг харуулж байна.



Б.2.3 Дотоод аудитын үр дүнд төсвийн хөрөнгийг анхан шатны баримтгүй зарцуулах, зориулалт бусаар зарцуулах зэрэг зөрчил буурсан байна.

Дотоод аудитын гол зорилго болох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласнаар 2020 онд мөрдвөл зохих 11 хуулийн 114 заалтын хэрэгжилт 89.8 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 2.9 хувиар, бусад 48 эрх зүйн актын хэрэгжилт 89.7 хувь буюу өмнөх оны үзүүлэлтээс 0.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй гарсан байна. Тухайлбал нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулснаар төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, өр, авлага үндэслэлгүй хаах, төсвийн хөрөнгийг бусдад зээлдүүлж, түр ашиглуулах, үндсэн баримтгүй зарцуулсан болон данс бүртгэлд тусгаагүй зэрэг зөрчил буурсан байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:


**ДОРНОД АЙМГИЙН САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА**
Дорнод аймаг, Хэрлэн сум, 10 дугаар баг
Засаг даргын Тамгын газрын 3 дугаар байр
Утас/ факс: 7058-3168,
Sankhuu_audit_do@yahoo.com

2021. 10. 29 № 302
танай _____ -ны № _____ -т

Г Санал хүргүүлэх тухай Г

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газраас "Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланттай танилцаж дараах саналыг хүргүүлж байна.

Тус байгууллагад өгсөн дүгнэлт, зөвлөмжтэй санал нэг байгаа бөгөөд харин "Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд хяналт тавих чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна" гэдэг дүгнэлтийн тухайд дараах тайлбарыг хүргүүлж байна.

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газраас "Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт"-д хийсэн аудит, "Орон нутгийн төсвийн 2019, 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн аудитад тус байгууллагад хамааралтай дараах дүгнэлтийг өгсөн билээ. Үүнд:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдэд дотоод хяналт шалгалтын чиг үүрэг хэрэгжээгүй байна. Санхүүгийн хяналт, аудитын албаны хийж байгаа хяналт нь цаг хугацааны хувьд оновчтой бус байна, түүнчлэн төлөвлөлтөд бус гүйцэтгэлд хяналт шалгалтыг түлхүү хандуулж байна, иймд аймгийн Засаг дарга дотоод аудитын төлөвлөгөөг батлахдаа хууль, журмыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор цаг хугацааг зөв хуваарилж батлах.

2.Аймгийн хэмжээнд өгсөн дүгнэлт, зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг хангуулах

Үүний дагуу тайлант 2021 онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн "2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаа хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, үр дүн үр ашиг"-т хийсэн аудитаар өгсөн дүгнэлт, зөвлөмж, шаардлагыг хэрэгжүүлсэн байдал, 2020 оны гүйцэтгэл, 2021 оны явцын байдалд хяналт тавихаар төлөвлөн "2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаа хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, үр дүн үр ашиг"-т хийсэн аудитаар өгсөн дүгнэлт, зөвлөмж, шаардлагыг хэрэгжүүлсэн байдалд хяналт шалгалтыг хийж дууссан ба хөндлөнгийн аудитын байгууллагаас өгсөн шаардлагыг засан залруулаагүй нийт 1,278.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 76.4 сая төгрөгийн зөрчилд улсын ахлах байцаагчийн 16 акт тогтоож, 119.5 сая төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн 7 албан шаардлага өгч, 1,082.1 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгч ажилласан.

Дорнод аймгийн 14 сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн "2020-2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаа"-нд дотоод аудитыг хийж дууссан, аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн "2020-2021 оны

160520001



2

хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаа"-нд хяналт шалгалтыг эхлүүлээд хүлээгдэж буй гүйцэтгэлтэй байна.

Хамтран ажилласан танд талархаж байна.

ДАРГА  Б.САРАНЧИМЭГ

ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

1. Б.1.2 дах асуудал нь дотоод аудитын үр дүнд хамааралтай тул аудитын тайланд хэвээр үлдээв.



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Төрийн байгууллагын дотоод аудитын эрх зүйн зохицуулалт уялдаа холбоогүй байна.
2. Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэггүй байна.
3. Төрийн байгууллагын дотоод аудитын нэгжийн зорилго, эрх мэдэл, үүрэг хариуцлагыг Дотоод аудитын дүрэмд тусгасан байна.
4. Санхүүгийн хяналт, аудитын алба нь чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх бүтэц, хөрөнгө, орон тоотой байна.
5. Хараат бусаар ажиллах нөхцөл боломжоор бүрэн хангаагүй байна.
6. Дотоод аудиторуд нь хууль, дүрэмд заасан шалгуурыг бүрэн хангаагүй байна.
7. Дотоод аудитын дүрэмд заасны дагуу дотоод аудитын хороог байгуулаагүй байна.
8. Дотоод аудитын нэгж чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.
9. Дотоод аудитын нэгжийн дүрмийг шинэчлэн боловсруулаагүй байна.
10. Дотоод аудитын тайланг иргэд олон нийтэд мэдээлэх мэдээллийн нэгдсэн сан байхгүй байна.
11. Сангийн яаманд холбогдох мэдээ, тайланг хүргүүлж ажилласан байна.
12. Санхүүгийн хяналт, аудитын албанд чанарын хяналтын үнэлгээ хийгдээгүй байна.
13. Дотоод аудитаар өгсөн зөвлөмжийг бүртгэн, биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй байна.
14. Дотоод аудитын үр дүнд төсвийн хөрөнгийг анхан шатны баримтгүй зарцуулах, зориулалт бусаар зарцуулах зэрэг зөрчил буурсан байна.

Аудитаар 5 зөвлөмж өгч, Үндэсний аудитын газрын нэгтгэсэн тайланд тусгуулах 2 саналыг хүргүүллээ.

САНАЛ:

Үндэсний аудитын газарт:

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлүүлэх талаар холбогдох газарт уламжлах. Үүнд:

1. Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5. "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 16.5.6. дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх," гэж заасан ч хэрхэн яаж хэрэгжүүлэхийг хууль, дүрмээр заагаагүй тул Сангийн яаманд санал хүргүүлэх.
2. Засгийн газрын тогтоолоор батлагдсан аймгийн ЗДТГ-ын бүтэц дэх Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэггүй байхад дотоод аудитын хэлтэс гэсэн нь хууль, дүрэмтэй нийцэхгүй байгаа тул Сангийн яаманд санал хүргүүлэх.



ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга болон Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд:

1. Дотоод аудитуудыг холбогдох сургалтад хамруулж, дүрэмд заасан шалгуурыг бүрэн хангуулах.
2. Дотоод аудитын дүрэм, аргачлалд заасны дагуу дотоод аудитын хороог байгуулах.
3. Дотоод аудитын төлөвлөгөөг үр дүнтэй байхаар тооцож Төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг тусган баталж байх.
4. Дотоод аудитын албаны дүрмийг шинэчлэн боловсруулах.
5. Дотоод аудитаар тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах дэмжлэг үзүүлэхэд анхаарч ажиллах.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2022 оны 10 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.



ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2021 оны 11 сарын 01 өдөр

Дугаар 18

Чойбалсан хот

Г Тайлан баталгаажуулах тухай 7

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитын тайланг УАГ-ын аудитын гуравдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Дорнод аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга Б.Саранчимэг нарт хүргүүлсүгэй.
3. Гүйцэтгэлийн аудитаар зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Б.Батжаргалд даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

011010014

